

МОНГОЛ УЛС, АНУ-ЫН ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр, Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч Жорж Буш нар Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын уламжлалт найрсаг харилцааг өнөөдөр дахин баталж, хоёр улсын Ерөнхийлөгч нарын 2004 оны долдугаар сарын 15-ны өдрийн Хамтарсан мэдэгдэлд тунхагласан ардчилсан хоёр орны хамтын үнэт зүйлс, стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан иж бүрэн түншлэлийн удирдах зарчмыг тодорхойлж, цар хүрээг нь өргөтгөхөөр тохиров.

Катрина хар шуурганд нэрвэгдэгсдэд халуун сэтгэлээр хандаж, санхүүгийн өгөөмөр туслалцаа үзүүлсэнд Монгол Улсын Засгийн газар, ард түмэнд АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш ард түмнийхээ нэрийн өмнөөс талархал илэрхийлэв. Монгол Улс хүний эрх, иргэний эрх чөлөөг хүндэтгэсэн, хувийн хэвшил зонхилсон чөлөөт зах зээлийн эдийн засгийг бэхжүүлж, боловсронгуй, тогтвортой ардчиллыг төлөвшүүлэн хөгжүүлэх үйлсдээ ахиц дэвшил гаргаж байгаад Ерөнхийлөгч Ж.Буш баяр хүргэв.

Тэрээр Мянганы сорилтын сангаас тусламж авахаар шалгарсан Монголын ард түмэнд Америкийн ард түмний өмнөөс баяр хүргэв. Эдийн засгийн өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулж, улс төр, эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлээ цаашид хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газрын тууштай бодлогыг тусгасан гэрээг Мянганы сорилтын сантай амжилттай байгуулна гэж найдаж буйгаа тэрээр мөн илэрхийлэв.

Хуулийг дээдлэх, сайн засаглал, ил тод байдлыг хангах, төрийн хариуцлагын тогтолцоог төлөвшүүлэх нь ардчиллыг бэхжүүлж, улс орныг хөгжүүлэн цэцэглүүлэхэд ач холбогдолтой болохыг харгалзан Авилгалын эсрэг НҮБ-ын Конвенцийг Монгол Улс соёрхон баталсныг Ерөнхийлөгч нар өндрөөр үнэлэв.

Ерөнхийлөгч нар Монгол Улсыг бүс нутгийн болон олон улсын улс төр, эдийн засаг, санхүүгийн бүтцүүдэд хамруулах боломжийг эрэлхийлж хамтран ажиллахаар тогтов. Хүн наймаалах, мөнгө хуурамчаар үйлдэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зэрэг зохион байгуулалттай, үндэстэн дамнасан бүх төрлийн гэмт хэргийн эсрэг хамтын ажиллагаагаа идэвхжүүлэхээр тэд тохиров.

Монгол Улс нь үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг зогсооход чиглэсэн Аюулгүй байдлын санаачилгыг дэмжиж, Зохион байгуулалттай, үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцид гарын үсэг зурж, соёрхон батлахаа илэрхийлснийг Ерөнхийлөгч Ж.Буш сайшаав.

Ерөнхийлөгч нар Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний

талаар хэлэлцээд, эдгээр арга хэмжээ нь хоёр талын эдийн засаг, худалдааны харилцааг улам бэхжүүлнэ гэж найдаж буйгаа илэрхийлэв.

Ерөнхийлөгч нар шувууны болон бусад төрлийн гоц халдварт ханиад нь хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүйг харгалзан, Шувууны болон гоц халдварт ханиадны эсрэг Олон улсын түншлэлийн хүрээнд хоёр болон олон талаар хамтран ажиллахын чухлыг санал нэгтэй тэмдэглэв.

Ерөнхийлөгч Н.Энхбаяр, Ерөнхийлөгч Ж.Буш нар олон улсын энх тайван, аюулгүй байдалд занал учруулж буй терроризмын эсрэг тэмцэх шийдвэр төгс байгаагаа цохон тэмдэглэв. Афганистан, Иракт байдлыг тогтворжуулах, сэргээн босгох болон Ирак дахь энхийг сахиулах олон үндэстний цэргийн хүчинд Монгол Улс оролцож байгаад Ерөнхийлөгч Ж.Буш талархал илэрхийлэв. Монгол Улс, АНУ хоёр олон улсын энх тайвныг дэмжих хүчин чармайлтад Монгол Улсын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхийн төлөө үргэлжлүүлэн ажиллахаар тохиров.

Чөлөөт, ардчилсан Ирак улсыг байгуулах нь Ойрхи Дорнодын ардчилал, энх тайван, тогтвортой байдалд чухал бөгөөд эл үйл явцад НҮБ тэргүүлэх үүрэг гүйцэтгэх ёстой гэж тэд мөн санал нэгтэй тэмдэглэв. Хоёр орны удирдагч нар олон талт хамтын ажиллагааны ач холбогдлыг тэмдэглэхийн сацуу НҮБ-ын үр өгөөжийг дээшлүүлэх үүднээс тус байгууллагын шинэчлэлийг үргэлжлүүлэхийн ач холбогдлыг цохон дурдав.

Түүнчлэн Ерөнхийлөгч Н.Энхбаяр, Ерөнхийлөгч Ж.Буш нар Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангид байлгах асуудлаарх зургаан талт хэлэлцээнд оролцогч талуудын 2005 оны 9 дүгээр сарын Хамтарсан мэдэгдлийг хэрэгжүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэв.

Ерөнхийлөгч нар хоёр орны ард түмний харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэхэд боловсрол, соёлын солилцоо чухал ач холбогдолтойг нотлоод, хоёр орны иргэдийн шууд хэлхээ холбоо, боловсролын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихээр тохиролцов.

Ерөнхийлөгч Ж.Буш АНУ-д магадлан итгэмжлэгдсэн, чанартай боловсролыг оюутан сурагчдад олгох чадавхи бүхий Улаанбаатар хотын Олон улсын сургуулийн тухай хоёр талын хэлэлцээрийг соёрхон баталсанд талархал илэрхийлэв. Ерөнхийлөгч нар Энх тайвны корпус Монгол Улсад хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлж, Монголын хөгжилд нааштай хувь нэмэр оруулж буйг тэмдэглэв.

Ерөнхийлөгч нар Монгол Улс, АНУ-ын харилцаа нь бие биенээ хүндэтгэсэн, эрх тэгш түншлэлд тулгуурлан цаашид ч өргөжин хөгжинө гэдэгт итгэл төгс байгаагаа илэрхийлж, энэ нь хоёр орны үндэсний эрх ашигт нийцнэ гэдгийг дахин нотлов.

*Улаанбаатар хот
2005 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр*